



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 79

Улаанбаатар хот

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5^{1.2} дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Салбарын хяналт шалгалтын 2023 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Энэ тогтоолын 1-д заасан төлөвлөгөөнд нийцүүлэн тухайн салбарын хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг баталж, хяналтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллахыг салбарын хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдэд тус тус үүрэг болгосугай.

3.Хяналт шалгалтын үйл ажиллагаанд шаардагдах зардлыг 2023 оны батлагдсан төсөвтөө багтаан, шаардлагатай бол зохицуулалт хийн санхүүжүүлж, цаашид холбогдох эх үүсвэрийг жил бүрийн улсын төсвийн төсөлд батлуулж байхыг Засгийн газрын холбогдох гишүүд, Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

4.Салбар хоорондын уялдаа холбоог хангаж, хяналт шалгалтыг давхардуулахгүй, бүртгэл, хяналтын удирдлагын нэгдсэн цахим системийг шинэчилж, хэвийн, аюулгүй байдлыг ханган хариуцаж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН**

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа	Хяналт шалгалтын байгууллага
1	2	3	4	5	6	7	8
Төлөвлөгөөт хяналт шалгалт							
1.	Стандарт хэмжил зүйн хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 283 объектод төлөвлөгөөт шалгалт хийх.	Улсын төсөв	Шалгалт хийсэн объектын тоо, гүйцэтгэлийн хувь, Хууль сахин мөрдөлтийн түвшин, Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт, Илрүүлсэн зөрчил арилгуулалтын хувь, Эрсдэлийн түвшин буурсан объектын хувь, тоо	Хэмжил зүйн хяналтаар: 294 объектыг шалгалтад хамрагдаж, 243 объектод 1752 зөрчил илрүүлснээс 18.6 хувийг арилгуулсан. 189 объектын эрсдэлийн түвшнийг бууруулсан.	Шалгалтад хамрагдсан объектын хууль сахин мөрдөлтийн түвшнийг 10.0 хувиар нэмэгдүүлсэн байна. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. Илэрсэн зөрчлийг 100 хувь арилгуулсан байна. Объектын эрсдэлийн түвшнийг бууруулсан байна.	I-IV улирал	Стандарт, хэмжил зүйн газар, Орон нутаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсүүд
Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт							
1.	Шинээр баригдаж буй орон сууцны барилгуудад суурилуулж буй ус, дулаан, цахилгааны хэмжих хэрэгслүүдийн хэмжлийн нэгдмэл	Улсын төсөв	Шалгалт хийсэн объектын тоо, Илрүүлсэн зөрчил арилгуулалтын хувь, Улсын байцаагчийн гаргасан	-	Шалгалтад хамрагдсан объектын хууль сахин мөрдөлтийн түвшнийг 10.0 хувиар нэмэгдүүлсэн байна. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. Илэрсэн	II-III улирал	Стандарт, хэмжил зүйн газрын Хэмжил зүйн бодлогын газар, Орон нутаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсүүд

	байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх.		шийдвэрийн биелэлт		зөрчлийг 100 хувь арилгуулсан байна. Объектын эрсдэлийн түвшнийг бууруулсан байна.		
2.	Үнэт металл, эрдэнийн чулуугаар хийсэн эдлэл худалдан борлуулдаг худалдааны төв болон дэлгүүр (лангуу, түрээслэгч)-т урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх.	Улсын төсөв	Шалгалт хийсэн объектын тоо, гүйцэтгэлийн хувь, Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт, Илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, Эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь	Сорьцын хяналтаар: 15 худалдааны төв, дэлгүүр шалгалтад 129666 бүтээгдэхүүнийг хамруулж, 5965 зөрчил илрүүлснээс 100 хувь арилгуулсан. Илэрсэн зөрчилд зөрчлийг арилгах албан шаардлага өгч шийдвэрлэсэн. 5 худалдааны төв, дэлгүүрийн эрсдэлийн түвшинг бууруулсан.	15-аас доошгүй худалдааны төв, дэлгүүрийн 130000 бүтээгдэхүүнийг хамруулна. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн бүрэн хангуулсан байна. Илэрсэн зөрчлийг 80 хувь арилгуулсан байна.	II-III улирал	Стандарт, хэмжил зүйн газрын Сорьцын хяналтын газар, Орон нутаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсүүд
Төлөвлөгөөт бус хяналт шалгалт							
1.	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх.	-	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт (хувь), Зөрчил арилгалт (хувь)	2022 онд төлөвлөгөөт бус шалгалтад 15214 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулсан байна.	Өргөдөл, гомдлыг хууль, журмын дагуу 100 хувь шийдвэрлэж, үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлсэн байна.	I-IV улирал	Стандарт, хэмжил зүйн газар, Орон нутаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсүүд
Гүйцэтгэлийн хяналт шалгалт							

1.	<p>Өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлагын биелэлтийг хангуулахаар гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх.</p>	-	<p>Албан шаардлагын биелэлт (тоо, хувь) Арилгуулсан зөрчлийн (тоо, хувь) Эрсдэлийн түвшин буурсан объектын (тоо, хувь)</p>	<p>2022 онд төлөвлөгөөт бус шалгалт, урьдчилан сэргийлэх шалгалтын хүрээнд илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар нийт 17579 заалттай 3622 албан шаардлага хүргүүлсэний 76.6 хувь биелэгдсэн.</p>	<p>Албан шаардлагаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг дүгнэж, тайлагнасан байна.</p>	<p>II-IV улирал</p>	<p>Стандарт, хэмжил зүйн газар, Орон нутаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсүүд</p>
----	--	---	--	---	---	---------------------	--